



## ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2018 оны 03 сарын 20 өдөр

Дугаар 04

Өндөрхаан

### ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Хурлын 2018 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 11 цаг 00 минутад аймгийн Засаг даргын Тамгын газрын Иргэний танхимд Төрийн албаны салбар зөвлөлийн гишүүн Г.Болд, Б.Сүнгээ, Б.Баярсайхан, Л.Бат-Октябрь, Г.Лхагвахатан, нарийн бичгийн дарга Ч.Болормаа нарын бүрэлдэхүүнтэй Төрийн албаны салбар зөвлөлийн гишүүн Ж.Гантулга удирдан эхлүүлэв.

#### Хэлэлцсэн асуудал:

1. Батширээт сумын газрын даамлаар Ц.Зулжаргалыг түр томилох тухай
2. Өмнөдэлгэр сум ЗДТГ-ын дарга Л.Баярмаагийн гаргасан өргөдөл хэлэлцэх  
-Комисс томилох
3. Төрийн үйлчилгээний удирдах албан тушаалтны сонгон шалгаруулалтын дүнгийн тухай
4. Төрийн албаны мэргэшлийн шалгалтын комисс томилох тухай
5. Шалган зааварлах ажлын тухай
6. Баян-Адрага сумын ЗДТГ-ын даргын сул орон тоог зарлах тухай

#### СОНССОН НЬ 1:

**Ж.Гантулга:** Батширээт сумын газрын даамлаар Ц.Зулжаргалыг түр томилох тухай гэж байгаа. Энэ түр томилох асуудал төрийн албаны зөвлөлийн хэлэлцэх асуудалд орж ирэх үү.

**Б.Баярсайхан:** Түр орлон гүйцэтгэх журамд нөөцөд бүртгэлтэй иргэнийг томилно гэсэн байгаа. Тиймээс салбар зөвлөл нөөцөд бүртгэлтэй байна уу үгүй юу гэдэг мэдээлэл өгөөд болно.

**Ч.Болормаа:** Ц.Зулжаргал нь 2016 оны 5 дугаар сарын 28-ны өдөр Өмнөдэлгэр сум ЗДТГ-ын газрын даамал 73,5 оноо авч нөөцөд бүртгэгдсэн.

**Ж.Гантулга:** Энэ хүн бол нөөцөд байна томилох эрх нь бол төсвийн шууд захирагчид байгаа. Тиймээс энэ бол төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн хэлэлцэх асуудал биш зүгээр лавлагаа мэдээлэл өгөх асуудал.

#### ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Газрын харилцаа барилга хот байгуулалтын газарт Ц.Зулжаргалыг нөөцөд бүртгэлтэй байгаа мэдээллийг албан бичгээр өгөх

#### СОНССОН НЬ 2:

**Ж.Гантулга:** Өмнөдэлгэр сум ЗДТГ-ын дарга Л.Баярмаагийн гаргасан өргөдлийг уншиж танилцуулав. Энэ нь төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.3-д заасан маргаан гэж үзэж байгаа учраас салбар зөвлөлөөр шийдвэрлүүлэх гомдол гаргаж байна. Мөн ээлжийн амралт олгох захирамжаа бичгээр гаргаж ээлжийн амралт олгох олговор ажилласан хоногийн мөнгө тооцуулж олгуулахыг даалгаж байна гэсэн байна. Энэ өргөдөл дээр комисс томилон ажиллах хэрэгтэй.

**Б.Баярсайхан:** Комисс томилох нь зүйтэй.

2//.

**Ж.Гантулга:** Комиссын дарга Л.Бат-Октябрь гишүүдэд Ж.Болд, Г.Лхагвахатан нарыг оруулах саналтай байна.

#### ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Гишүүдийн 100 хувийн саналаар Өмнөдэлгэр сум ЗДТГ-ын дарга Л.Баярмаагийн гаргасан өргөдлийг хянан шалгах комиссыг 3 хүний бүрэлдэхүүнтэй томилохоор шийдвэрлэв.

#### СОНССОН НЬ 3:

**Ч.Болормаа:** Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 60 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах жухам"-ын 3 дугаар зүйлийн 3.1 дэх заалтыг үндэслэн сонгон шалгаруулалтын талаарх мэдээлэл, зарыг Хэнтий ТВ Khentii.mn, сайт болон сумдруу албан бичиг хүргүүлэн цаг хугацаанд нь хүргүүлж ажилласан.

2018 оны 1 дүгээр сарын 10-ны 02 дугаар тогтоолоор томилогдсон сонгон шалгаруулалтын комисс ажилласан.

Цэнхэрмандал, Дэлгэрхаан, Жаргалтхаан, ХБУ, Баян-Адрага, Мөрөн сумдын соёлын төвийн эрхлэгчийн нийт 6 сул сул орон тоо зарлагдсан.

2018 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн 08:30-17:30 цагийн хоороонд төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулалтад орох иргэдийг аймгийн ЗДТГ-ын 207 тоот өрөөнд бүртгэв.

Нийт 4 иргэн бүртгүүлснээс Дэлгэрхаан 1, Жаргалтхаан-1, Мөрөн-1, Цэнхэрмандал суманд-1 иргэн бүртгүүлэв.

Иргэдийн мэдээллийг цахим бүртгэлд шивж оруулсан.

2018 оны 3 дугаар сарын 15-ны өдөр Нийгмийн бодлогын хэлтсийн даргын өрөөнд бичиг баримтын шалгалтыг хийж гүйцэтгэсэн.

2018 оны 3 дугаар сарын 16-ны өдөр шалгалтыг Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн мэдээлэл зүйн кабинетад 09:00 цагт эхлүүлж, сорилын шалгалтыг 09:10 минутад эхлүүлж Цэнхэрмандал сумын Соёлын төвийн эрхлэгчид Э.Навчаа 23 оноо, Мөрөн сумын Соёлын төвийн эрхлэгчид Ц.Цэндбаяр 18 оноо, Жаргалтхаан сумын Соёлын төвийн эрхлэгчид Эрдэнэсүвд 23 оноо, Дэлгэрхаан сумын Соёлын төвийн эрхлэгчид Золзаяа 18 оноо авч тэнцээгүй.

Тэнцээгүй иргэдэд заавар зөвлөгөө өгөн шалгалтын үйл ажиллагааг 10:30 минутад дуусгасан.

**Ж.Гантулга:** Сургалтанд хамруулах талаар чиглэл өгөх бүрэн эрх байна уу салбар зөвлөлд. Дахин зарлах уу. Г.Лхагвахатан даргаас саналыг авая. Г.Лхагвахатан: Сургалтанд хамруулж байгаад шалгалтыг зарлая.

#### ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Гишүүдийн 100 хувийн саналаар Соёлын төвийн эрхлэгч нарын сонгон шалгаруулалтыг дахин зарлахаар шийдвэрлэв.

## СОНССОН НЬ 3:

**Ч.Болормаа:** Төрийн албаны мэргэшлийн шалгалт 2018 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр явагдана.

**Ж.Гантулга:** Салбар комиссын даргаар Ж.Гантулга, нарийн бичгийн даргаар Ч.Болормаа, Гишүүдэд С.Бат-Эрдэнэ, Г.Болд, Г.Лхагвахатан нарыг оруулахыг санал болгож байна.

## ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Гишүүдийн 100 хувийн саналаар Төрийн албаны мэргэшлийн шалгалт авах комиссын бүрэлдэхүүнийг 5 хүний бүрэлдэхүүнтэй томилохоор шийдвэрлэв.

## СОНССОН НЬ 4:

**Ж.Гантулга:** Шалган зааварлах ажлыг яаж зохион байгуулах вэ

**Б.Баярсайхан:** Өмнө явсан байгууллагууддаа дахин явахгүйгээр хувиарлавал ямар вэ

**Ж.Гантулга:** Өмнө нь 3 аараа баг болоод явдаг очоод үзэхэд давхцаад дараа нь илтгэх хуудсаа бичихэд төвөгтэй байдаг. Тиймээс бие дааж 1 юмуу 2 байгууллагад чанартай яваад үзвэл яасан юм. Тэгээд эргээд тэрийгээ өөрсдөө танилцуулаад өөрсдөө илтгэх хуудсаа бичээд танилцуулбал. Сумд бол Бор-Өндөр, Баянмөнх. Саналыг дэмжиж байна уу.

**Г.Болд:** саналыг дэмжиж байна.

**Ч.Болормаа:** Удирдамжид оруулах ажлын чиглэл

**Б.Баярсайхан:** Өмнөх удирдамжид гарсан ажлын чиглэл хангалттай тул тэр удирдамжийн дагуу гаргах.Хугацааг 4 сардаа багтаана гэж заагаад тухайн гишүүн тухайн байгууллагадаа 3-4 хоногийн өмнө өөрөө мэдэгдэнэ.

**Ж.Гантулга:** Удирдамждаа нарийвчлаад илтгэх хуудсаа удирдамжийнхаа дагуу бичээд танилцуулаад, цаашид анхаарах асуудлыг зөвлөмжөөр хүргүүлье.

**Б.Баярсайхан:** Илтгэх хуудсаа танилцуулахдаа Зөвлөмжийн төслөө боловсруулж ирэх

## ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Гишүүдийн саналыг үндэслэн агентлагуудыг гишүүдэд хувиарлан удирдамжийг боловсруулан гишүүдэд тарааж өгөхөөр шийдвэрлэв.

## СОНССОН НЬ 5:

**Ж.Гантулга:** Баян-Адрага сумын ЗДТГ-ын даргын сул орон тоо зарлах

**Ч.Болормаа:** Түр орлон гүйцэтгэж байгаа хүн нь Баян-Адрага сумынхаа ЗДТГ-ын даргын сонгон шалгаруулалтан дээр шалгалт өгөөд нөөцөд байгаа хүн. Төрийн албаны зөвлөлөөс асуусан танайх салбар зөвлөлөөрөө хэлэлцээд томилж болно гэсэн байгаа.

**Б.Баярсайхан:** 1-ээр гарсан хүн нь яасан юм. Тухайн албан тушаалдаа ажилласан юм уу

**Ч.Болормаа:** ЗДТГ-т төсвийн ерөнхийлөн захирагчаар ирсэн байгаа. Тухайн албан тушаалдаа ажиллаад шилжсэн.

**Б.Баярсайхан:** 2 дох хүн урагшаа шилждэг зарчим бол өмнөх хүн томилогдохгүй тохиолдолд 2 нь ургашаа шилжинэ гэсэн зарчим. Энэ хүний хувьд 2-оос нэг рүү орж байгаа гэсэн агуулга биш нөөцөөсөө орж байгаа гэсэн үг. Удирдах албан тушаалтан болохоор хэцүү

**Ж.Гантулга:** УИХ-ын тогтоол байгаа төсвийн шууд захирагчийг заавал сул орон тоог зарлана гэж байгаа.

**Б.Баярсайхан:** Сул орон тоог зарласан дээр

**Ж.Гантулга:** 2 журам зөрчилдөөд байна. Энэн дээр УИХ-ын тогтоолоо бариад шийдвэрлэсэн дээр

4//.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Гишүүдийн 100 хувийн саналаар Баян-Адрага сумын ЗДТГ-ын даргын сул орон тоог зарлахаар шийдвэрлэв.

Хурлын үйл ажиллагаа 12:30 минутад дуусав.

ХУРАЛ УДИРДСАН:



Ж.ГАНТУЛГА

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТӨЛСӨН:

*Ч.Болормаа*

Ч.БОЛОРМАА